



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2025.09.18 № 40

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл  
ажиллагааны талаар асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газар стратегийн ач холбогдол бүхий орд газруудаа эдийн засгийн эргэлтэд оруулж үнэ цэнэ, үр өгөөж бий болгох зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийг байгуулж, улмаар уул уурхайн төрийн өмчит томоохон компаниудыг нэгтгэн, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах эрх, үүргийг хүлээлгэсэн байна.

Төрийн өмчит томоохон компаниудыг нэгтгэснээс хойш тус компанийн засаглал, стратеги төлөвлөлт тодорхойгүй, нэгдлээс бусад охин компаниудад үзүүлсэн менежментийн үйлчилгээ зэрэг нь хангалтгүй, хүний нөөцийн тоо хэт нэмэгдсэний улмаас удирдлагын зардал нь огцом өсөж, шийдвэр гаргах шат дамжлага нэмэгдсэнээр, ажлын хурд, бүтээмж удааширсан нь охин, хараат компаниудынхаа үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа талаар чуулганы нэгдсэн хуралдаан болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүдээс удаа дараа асуудал дэвшүүлж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бүрэлдэхүүнд танай үндсэн бүтцээс гадна Түлш, эрчим хүчний групп, Зэс металлын групп болон Дэд бүтэц, логистик группүүд ажиллаж байна. Эдгээр группүүдийн зорилго, зорилт, бүтэц бүрэлдэхүүн, ажлын уялдааны талаарх мэдээлэл болон өнгөрсөн хугацаанд дээрх группүүдийн гүйцэтгэсэн ажлын үр дүн, бодит үр ашгийн талаарх мэдээлэл, цаашид ийм давхардсан бүтэц байх хэрэгтэй, эсэх талаар;

2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бүрэлдэхүүнд алт, мөнгө, зэс, нүүрс, хүдэр зэрэг ашигт малтмалыг хайх, олборлох, баяжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 31 компани байдаг бөгөөд эдгээрээс улс, орон нутгийн төсөвт хэд нь татвар төлж ашигтай ажилладаг, хэд нь татаасаар үйл ажиллагаа явуулдаг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг компани тус бүрээр;

3. “Эрдэнэс Монгол” ХХК нь компанийнхаа дүрэмд охин компаниудаас жил бүр менежментийн төлбөр авч байгаа тухай заасан байдаг. 2022-2025 оны хооронд хэдэн компаниас хэдэн төгрөгийн менежментийн төлбөр авсан талаарх болон төлбөрийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

A handwritten signature in black ink, appearing to read 'P. SADDORJ', is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a unique identification number at the bottom: 'TVC3754 9023051393 0067154'.

Р.СЭДДОРЖ

2025000067